

Гамшигт тэсвэртэй Эрдэнэт хот төсөл

Улс:	Монгол
Төслийн дугаар:	50533
Бизнесийн салбар:	Хот суурин газар ба байгаль орчны дэд бүтэц
Төрөл:	Төрийн
Байгаль орчны ангилал:	В
Зөвшөөрлийн тов:	2020 оны 6 дугаар сарын 10-ны өдөр
Төлөв:	Концепцийн Хурлаар орсон
Төслийн товч танилцуулга (PSD)-ыг нийтэлсэн огноо:	2020 оны 4 дугаар сарын 6-ны өдөр

Төслийн танилцуулга

Эрдэнэт хотын үерийн хамгааллатын дэд бүтцийг шинэчлэх, өргөтгөх мөн цэвэр усны сүлжээг сайжруулах зорилгоор Орхон аймагт дамжуулан зээлдүүлэхээр Монгол улсад олгож буй 7 сая ам.доллар хүртэлх (6.26 сая евро) засгийн газрын зээл. Эрдэнэт хот нь үер усны аюулд өртөмтгий, хотын оршин суугчдын талаас доор хувьд үйлчилгээ үзүүлж буй усны сүлжээ нь үр ашиггүй, усны алдагдалтай ажилладаг. Төсөл нь хотын гамшигт тэсвэртэй байдлыг хангах мөн цэвэр усны сүлжээний алдагдалыг бууруулзах замаар ундны усны хүртээмжийг сайжруулах болно. Энэхүү төсөл нь олон улсын хандивлагч донор байгууллагуудаас 7 сая ам доллар хүртэлх буцалтгүй тусламжийн хамтаар хамтран санхүүжүүлэх толовтэй байна.

Төслийн зорилго

Тус Төсөл хэрэгжснээр, үер усны аюул 40-50 хувь буурах бөгөөд ойролцоогоор 11,000 оршин суугчид найдвартай аюулгүй ундны усны сүлжээнд холбогдох болно. Төслийн хүрээнд хийгдэх ажлын үр дүнд системийн усны алдагдал 15 хувиар буурах боломжтой.

Шилжилтийн нөлөөлөл

Тус төсөл нь байгаль орчны хөрөнгийн тогтвортой зохицуулалт, менежмент мөн гамшигт тэсвэртэй байдлыг бий болгох замаар “Ногоон” чанарыг дэмжих юм. Түүнчлэн нийтийн үйлчилгээ үзүүлдэг компани болох Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК-д Төрийн үйлчилгээний гэрээ нэвтрүүлэх, Компанийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах замаар “Сайн удирдлагыг” хангахад хувь нэмрээ оруулна. Компанийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Орхон аймагт үерийн хамгаалалтын дэд бүтцийн үйлжиллагаа

Үйлчлүүлэгчийн мэдээлэл

МОНГОЛ УЛС болон Орхон аймаг

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

7,000,000 хүртэлх ам. доллар

Төслийн нийт өртөг

14,000,000 хүртэлх ам. Доллар

Банкны оролцоо

ЕСБХБ нь энэхүү төслийг боловсруулахад шаардлагатай, зах зээлийн жишиг дунджаас дээгүүр зээлийн нөхцөл санал болгож байна.

ЕСБХБ-ны оролцоо нь бодлогын, салбарын, институцын, хууль эрх зүйн тогтолцоо эсвэл тухайн орон болон салбарын практикийг (жишээ нь: эрчим хүч болон усны зардалд тулгуурласан тарифийн түвшинг нэвтрүүлэх) сайжруулахаар чиглэсэн байвал нэмэлт гэж үздэг.

Харилцагч нь ЕСБХБ-ны олон улсын стандарт-д тулгуурласан худалдан авалтын туршлагаас суралцах сонирхолтой.

ЕСБХБ нь энэхүү төслийн зорилтыг бодитоор хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх туршлага, инноваци, мэдлэг болон ур чадварыг санал болгож байна.

Байгаль орчин, нийгмийн харилцааны тойм

Тус Төсөл нь ЕСБХБ-ны 2014 оны Байгаль орчин, нийгмийн харилцааны бодлогын дагуу “В” ангилалд багтсан. Байгаль орчин, нийгмийн харилцааны нарийвчилсан үнэлгээнд (ESDD) хэрэгжүүлэгч байгууллагын одоогийн ажиллагаа, санал болгож буй нэн тэргүүний хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, нийгмийн харилцааны хараат бус аудит багтсан болно. ESDD нь төсөл хэрэгжснээр одоогийн системийн усны алдагдалыг бууруулж, ус түгээх төвд болон хотын усны сүлжээнд нийлүүлж буй ундны усны найдвартай байдал болон чанарыг дотоодын болон ЕХ-ны шаардлагад нийцүүлэн сайжруулах болно гэж дүгнэсэн. Төсөл хэрэгжснээр үер усны давтамж буурах зэрэг нийгмийн ихээхэн үр ашиг гарах юм. Байгаль орчин, нийгмийн (E&S) эрсдэл болон сөрөг нөлөө нь голчлон барилгын ажилтай холбоотой байх бөгөөд харьцангуй хязгаарлагдмал, богино хугацааны бөгөөд Байгаль орчин, нийгмийн ажлын төлөвлөгөөнд (ESAP) болон барилгын ажлын Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан барилгын ажлын сайн практикийг хангаж мөн оролцогч талуудын оролцоотойгоор эрсдлийг бууруулах боломжтой.

Барилгын ажил нь хот суурин газар явагдах бөгөөд үерийн усны хадгалах цэгүүдийн байрлалд ямарваа нэг биет шилжилт хөдөлгөөн аль эсвэл үндэсний болон орон нутгийн хамгаалалттай бүс болон эмзэг орчин/бүс байхгүй болно. Төсөлд шаардлагатай газар нутаг нь орон нутгийн өмчит газар бөгөөд суурьшлын бүс биш, одоо буй дэд бүтцийн харалдаа учир эдийн засгийн шилжилт хөдөлгөөний хувьд хязгаарлагдмал. Байгаль орчин, нийгмийн нөлөө нь барилгын ажилтай холбоотой тоног төхөөрөмжийн дуу чимээ, богино хугацааны хөдөлгөөний ачаалал үүнтэй холбоотой агаарын бохирдолын түвшингийн нэмэгдэл, түр хугацааны гарц орцны хязгаарлалт болон мэргэжлийн болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал хамрах бөгөөд барилгын ажлын сайн практикаар эрсдлийг бууруулах болно.

Хотын цэвэр усны шугам сүлжээ нь Зөвлөлтийн үед баригдсан бөгөөд одоогоор усны алдагдал их маш муу нөхцөл байдалтай байна. Төслийн хэрэгжилт болон үйл ажиллагааг хэд хэдэн байгууллага хариуцах бөгөөд үүнд Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨҮГ барилгын ажлыг, Эрдэнэт ус, дулаан түгээс сүлжээ ОНӨХК нь цэвэр усны шугам сүлжээний үйл ажиллагаа болон засвар арчилгааг, Хот тохижуулах

газар үерийн хамгааллатын системийн үйл ажиллагаа болон засвар арчилгааг хариуцна. ESDD хүрээнд эдгээр байгууллагуудын хүчин чадал, нөөц бололцоог судлаж одоо хэрэгжүүлж буй Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн бодлого (EHS) болон системийг сайжруулах шаардлагатайг тодорхойлсон. Мөн одоогийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, талуудын оролцооны практик нь ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагад (EBRD PRs) нийцэхийн тулд цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж тодорхойлсон.

ESDD- нь Байгаль орчин нийгмийн харилцааны менежментийн систем боловсруулах барилгын нөлөөг удирдах гүйцэтгэгчийн байгаль орчин, хийгмийн менежментийн төлөвлөгөө, зураг төсөл болон үйл ажиллагааны явцад олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хэмжигдэхүүнийг тусгасан байх зэрэг ажлууд багтсан болно. Талуудын оролцооны төлөвлөгөө (SEP) боловсруулсан бөгөөд үүнийг төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэгжүүлэх болно. Үерийн тохиолдлын онц байдлын хариу үйлдийн төлөвлөгөө мөн боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс мониторинг шалгалт хийх болно. Банкны зүгээс зээлийн хэлэлцээрт зурснаас хойш хэрэгжих Корпорацийн хөгжүүлэх хөтөлбөр болон Төслийн хэрэгжилтийн дэмлэгийн техник хамтын ажиллагааны хэрэгжилт шаардлагын дагуу явж байгаа эсэхийг хянана.

Техник хамтын ажиллагаа

Техник хамтын ажиллагаа (ТХА)-ны дараах ажлууд Төсөлд тус дэм болно. Үүнд:

Зээлийн гэрээнд гарын үсэг зурахын өмнө:

ТХА 1: Техник, эдийн засгийн үнэлгээ. Энэ ажлын өртөг нь 314,900 евро хүртэл хэмжээтэй байх ба ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сангаас (SSF) санхүүждэг Дэд бүтцийн төслийн бэлтгэлийн сангаас санхүүжүүлнэ.

Зээлийн гэрээнд гарын үсэг зурсны дараа:

ТХА 2: Компаний хөгжлийн хөтөлбөр. Энэ ажлын өртөг зардал 350,000 хүртэлх евро болох тооцоотой бөгөөд олон улсын аль нэг хандивлагч, эсвэл ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сангаас санхүүжүүлэх хүсэлт тавьсан

ТХА 3: Төсөл хэрэгжилт болон худалдан авалтын дэмжлэг. Энэ ажлын өртөг зардал 650,000 хүртэлх евро байх бөгөөд олон улсын аль нэг хандивлагч, эсвэл ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF)-гаас санхүүжүүлэх хүсэлт тавьсан.

Компаний холбоо барих мэдээлэл

С.Нансалмаа

nansalmaass@yahoo.com

+976 70359168

Нутгийн удирдлагын ордон, Амарын талбай

Хүрэнбулаг баг, Баян-Өндөр сум,

Орхон аймаг, Монгол Улс

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг [EBRD Procurement](#) вэбсайтнаас авна уу:

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа, үйл ажиллагаатай холбоотой асуулт

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах хаяг:

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаархи олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн ил болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог. Төрийн хэвшлийн захирлуудын зөвлөлийн тайлан илтгэл авах хүсэлтийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг доорх холбоосоор ОНМБ-ын вэб хуудсанд хандан авна уу.

Төслийн Гомдлын Газар (ТГГ)

Төслийн Гомдлын Газар (ТГГ) нь ЕСБХБ-ны эгэх хариуцлагын механизм, арга хэрэгсэл юм. Энэ нь ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүд байгаль орчинд буюу нийгэмд хор хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй гэж үзсэн хувь хүн болон байгууллагын зүгээс гаргасан гомдлыг хараат бусаар хянан үзэх боломж олгодог.

Гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэл авахыг хүсвэл [Project Complaint Mechanism](#) вэб хуудсанд хандана уу. ТГГ-ын ажилтан (pcm@ebrd.com) гомдол гаргах, гомдлын бүртгэл ба шаардлагын шалгуурт хэрхэн нийцүүлэх тухай асуудлаар таны аливаа асуултанд **ТГГ-ын Үйл ажиллагааны журам -ын** дагуу хариулахад бэлэн байна.